



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 03 өдөр

Дугаар

A/368

Улаанбаатар хот

Авлигын эсрэг үйл ажиллагааны
2025 оны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн хэмжээнд хэрэгжүүлэх “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.

2. Авлигатай тэмцэх эсрэг үндэсний хөтөлбөр болон энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг даргын дэргэдэх болон эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангуулж, танилцуулж ажиллахыг дүүргийн Засаг даргын Тамгын газар (Ж.Бат-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



9023100756
9091904 СБТ23271

Ц.БАТТӨР


1825011048

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын
2025 оны 16 дугаар сарын 24 ны өдрийн
16/16 дугаар захирамжийн хавсралт



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АВЛИГААС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжүүлэх хугацаа	Хүрэх түвшин	Хэрэгжүүлэгч байгууллага
1	2 1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	3	4	5	6
1.1	Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг а/байгууллагын албан ёсны цахим хуудас; б/сошиал сувгууд; в/дотоод сүлжээ; г/хэвлэл мэдээллийн хэрэгсэл, д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц, е/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх	Түгээсэн хүрсэн үр дүнгийн талаар салбар хариуцсан ажилтанд тухай бүр тайлагнадаг байх; -Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших	Тухай бүр	Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг тогтмол байршуулж, олон нийтэд сурталчилсан байна	Дүүргийн төрийн бүх байгууллагууд
1.2	Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах	Өдөрлөг оролцсон иргэдээс байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт авч, түүнд үндэслэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байх; - Авлигатай тэмцэх газраас өрнүүлж буй аян, уриалгатай уялдсан байх; - Үр дүнг тооцсон байх.	2-р улиралд	Авлигатай тэмцэх газартай хамтран дүүргийн төр захиргааны албан хаагчдад авлигын эсрэг хууль тогтоомжоор нэгдсэн сургалт зохион байгуулах	Дүүргийн төрийн бүх байгууллагууд

1.3	Иргэдэд зориулсан өөрийн салбартай холбогдох цахим ном гарын авлага бүтээх, авлигын хор хөнөөлийг ойлгуулах, шүгэл үлээхийг уриалсан мэдээлэл, 110 дугаарыг сурталчлах	<ul style="list-style-type: none"> - Мэдээллийг Авлигатай тэмцэх газраас буюу баталгаат эх сурвалжаас авсан байх; - Байгууллагын эрх хэмжээний хүрээнд иргэд, олон нийт рүү чиглэсэн хэвлэмэл материалд оруулсан байх; - Үр дүнг нэгтгэн тайлагнасан байх; - Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших. 	Жилдээ	Байгууллагын ажиллагааны үйл эрхлэн гаргадаг гарын авлага, хэвлэмэл материалд авлигын хор хөнөөлийг ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулах, уриалсан мэдээлэл болон 110 дугаарыг оруулан таниулсан байх	 <p>Дүүргийн төрийн бүх байгууллагууд</p>
1.4	Өөрийн байгууллагын үйл ажиллагаа, авлигын хор хөнөөл, 110 тусгай дугаарыг сурталчилсан видео, контент бүтээх	<ul style="list-style-type: none"> - Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх; - Авлигын мэдээлэл 110 дугаарын утсыг сурталчилсан байх; - Олон нийтэд түгээсэн байх. 	Тухай бүр	1 контент бүтээж, олон нийтэд түгээх, байгууллагын цахим хуудсанд байршуулсан байна.	Дүүргийн төрийн бүх байгууллагууд
2. Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийн бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх					
2.1	Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх	<ul style="list-style-type: none"> - Салбар бүрт үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын нэгдсэн судалгааг гаргасан байх; - Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авсан байх; - Үр дүнг тооцож, тайлагнасан байх 	Жилдээ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авахдаа ил тод, нээлттэй сонгон шалгаруулалтыг хийж ажиллах	Дүүргийн төрийн бүх байгууллага

2.2	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан нээлттэй мэдээллийг өөрсдийн цахим хуудсанд байршуулах	Тус хуулийн 8 дугаар зүйлд заасан арга хэмжээг хэрэгжүүлсэн байх	Улирал бүр	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу холбогдох мэдээллийг улирал бүр shilen.gov.mn сайтад оруулж ил тод байдлыг хангах Байгууллагын цахим хуудсанд иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авах талбар үүсгэж, тусгай дугаар ажиллуулах	Дүүргийн төрийн бүх байгууллагууд
2.3	Байгууллагын цахим хуудсанд өөрчлөлт хийж иргэдийг мэдээлэл хайх, санал хүсэлт өгөхөд амар хялбар байдлаар өөрчлөх	Өөрчлөлт хийсэн байх	Жилдээ	Иргэдээс ирүүлсэн гомдлын агуулгыг багцлан ялгаж үр дүнтэй арга хэмжээ авч тайланг улирал бүр гаргах. Нийт ирсэн гомдлын шийдвэрлэлтийг нэгтгэн дүгнэж тайлагнасан байх	Дүүргийн төрийн бүх байгууллагууд
2.4	Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших	Нийт ирсэн гомдлыг нэгтгэн дүгнэж тайлагнасан байх	Тухай бүр	Иргэдээс ирүүлсэн гомдлын агуулгыг багцлан ялгаж үр дүнтэй арга хэмжээ авч тайланг улирал бүр гаргах. Нийт ирсэн гомдлын шийдвэрлэлтийг нэгтгэн дүгнэж тайлагнасан байх	Дүүргийн төрийн бүх байгууллагууд
3. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах					
3.1	Байгууллагын дотоод хяналтын механизмдыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх	А/Дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулж хэлтэс, алба бүрт дотоод хяналтын хяналт шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулах. Б/Илэрсэн зөрчил алдаа дутагдлыг авлигатай тэмцэх газарт тайлагнах	Жилдээ	Байгууллага бүр дотоод хяналтын багийн үйл ажиллагааг идэвхижүүлж, холбогдох чиглэлээр хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах	Дүүргийн төрийн бүх байгууллагууд
3.2	Өөрийн байгууллагад мөрдөгдөж буй дүрэм журамд шинэчлэл хийж авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх	Нийт мөрдөгдөж буй дүрэм журмын жагсаалтыг хүргүүлэх өөрчлөлт оруулсан дүрэм журмыг хүргүүлэх	Жилдээ	Өөрийн байгууллагад мөрдөгдөж буй дүрэм журамд шаардлагатай тохиолдолд шинэчлэл өөрчлөлт хийх Мөрдөгдөж буй нийт дүрэм журмын жагсаалтыг авлигатай тэмцэх газар хүргүүлэх	Дүүргийн төрийн бүх байгууллагууд

4. ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭГ САЙЖРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Гадаад шударга байдлын үнэлгээг сайжруулах чиглэлээр

4.1 Байгууллагын албан хаагчдад иргэдтэй хүндэтгэлтэй харилцах, ажлын цагийг баримтлах, ёс зүйн зөрчил гаргахгүй байх, иргэний гаргасан хүсэлтэд дурдсан асуудлыг бүрэн дүүрэн тайлбарлаж өгч байх, төрийн үйлчилгээг үзүүлэхдээ ах дүү, танил талынхаа нөлөөнд автахгүй байх, бусдад хууль бус давуу байдал олгохгүй байх, албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулахгүй байх, бусдаас шан харамж авахгүй байх, хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэхгүй байх, хувийн ашиг сонирхол гаргахгүй байх талаар баталгаа гаргуулах, эдгээр зөрчлийг гаргахгүй байхад чиглэсэн соён гэгээрүүлэх, сургалт зохион байгуулах;

4.2 Тухайн байгууллагаас иргэд, олон нийтэд үзүүлж буй үйлчилгээний хугацаа, чанар, хүртээмжид дүн шинжилгээ хийж, хүнд суртал, чирэгдэл үүсгэж буй шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, арилгахад чиглэсэн арга хэмжээ авах;

Бүх албан хаагчдаар баталгаа гаргуулсан байх;
Албан хаагчдад сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулсан байх

Дүн шинжилгээ, ажлын байрны зураглал хийсэн байх;
- Үр дүнгээс хамааран хүнд суртал, чирэгдлийг бууруулах арга хэмжээ авсан байх

Жилдээ

Жилдээ

-Засаг даргын Тамгын газар, эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллага, хороодын албан хаагчдад ёс зүйн сургалт зохион байгуулах
-Төрийн албанд ёс зүйн шаардлагыг хангасан иргэдийг ажилд авах соёлыг төлөвшүүлэх

Дүүргийн төрийн бүх байгууллагууд

Байгууллагын дүрэм, албан хаагчдын ажлын чиг үүрэгт дүн шинжилгээ хийж, албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх
-Иргэд үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авч дүн шинжилгээнд үндэслэн холбогдох арга хэмжээг авч ажиллах

Дүүргийн төрийн бүх байгууллагууд

Дотоод шударга байдлын үнэлгээг сайжруулах чиглэлээр



9023100758
9091904 # CB123271



4.3	Тухайн байгууллагын албан хаагчид албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах нь авлигын гэмт хэрэг болон зөрчлийн шинжтэй үйлдэл болох талаар нийт албан хаагчдад сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах;	Сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан байх;	4 дүгээр улиралд	Авлига үүсдэг хүчин зүйл, шалтгаан, нөхцлөөр албан хаагчдад сургалт зохион байгуулах	АТГ хамтран ЗДТГ
4.4	Байгууллагын дотоод шударга байдлыг нэмэгдүүлэх зорилгоор бүх албан хаагчдыг нууц санал асуулгад хамруулах арга хэмжээ авах, санал асуулгын үр дүнд үндэслэн Авлигатай тэмцэх газраас өгсөн чиглэл, зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авах;	Албан хаагчдыг санал асуулгад бүрэн хамруулсан байх; - АТГ-аас өгсөн зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлсэн байх	3 дугаар улиралд	Байгууллагууд бүх албан хаагчдаас нууц санал асуулга авах ажлыг зохион байгуулах	АТГ хамтран Дүүргийн төрийн бүх байгууллагууд
Бодлогод оролцогчдын үнэлгээг сайжруулах чиглэлээр					
4.5	Байгууллагын удирдах албан тушаалтан нийт албан хаагчдад шударга байдлын үнэлгээг сайжруулах чиглэсэн албан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, албан хаагчдаас гарсан авлигын эсрэг санал санаачилгыг дэмжин ажиллах	Нийт албан хаагчдад шударга байдлын үнэлгээг сайжруулахад чиглэсэн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулагдсан байх	Жилдээ	Байгууллагын албан хаагчдад шударга байдлын үнэлгээг сайжруулах талаар хэлэлцүүлэг зохион байгуулах	Дүүргийн төрийн бүх байгууллагууд
4.6	Шударга байдлын үнэлгээг сайжруулах чиглэлээр төрийн байгууллагуудад 1 сарын хугацаатай аян зохион байгуулах;	Харьяа байгууллагуудад албан бичиг хүргүүлж, үр дүнг тооцох	4 дүгээр улиралд	Дүүргийн төрийн захиргааны бүх байгууллагуудыг оролцуулан 1 сарын хугацаатай "Бид авлига ашиг сонирхлын зөрчилгүй хамт олон" аяныг зохион байгуулах	ЗДТГ

---000000---